



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/16/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn  
Аудитор: Ж.Наранчимэг  
Утас: 70359826 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Агуулга**

1. Санал дүгнэлт.....	2-3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.23 № 06

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ПРОКУРОРЫН  
ГАЗРЫН ДАРГА Л.БАТГЭРЭЛ  
ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc



### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,996,328.13</b>	<b>25,633,207.61</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
311	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>2,460,000.00</b>	<b>2,460,000.00</b>
31110	Төгрөг	2,460,000.00	2,460,000.00
33	<b>АВЛАГА</b>	<b>402,022.37</b>	<b>22.37</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	402,022.37	22.37
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		<b>23,173,185.24</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>18,134,305.76</b>	<b>23,173,185.24</b>
35410	Бичиг хэргийн материал	2,286,134.00	2,664,726.00
35420	Аж ахуйн материал	4,017,027.00	5,550,392.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,174,000.00	2,312,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,253,444.76	1,773,367.24
35470	Бусад хангамжийн материал	8,403,700.00	10,872,700.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>867,030,208.86</b>	<b>902,925,871.72</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
391	Газар	867,030,208.86	902,925,871.72
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>655,515,208.86</b>	<b>691,410,871.72</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	573,226,196.00	573,226,196.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,892,031.64)	(52,051,892.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	53,800,000.00	53,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,724,999.95)	(12,104,999.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,783,749.61	109,697,723.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,436,433.22)	(33,935,646.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,968,169.59	89,242,369.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,209,441.53)	(36,462,879.45)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>211,515,000.00</b>	<b>211,515,000.00</b>
39301	Програм хангамж	715,000.00	715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(715,000.00)	(715,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	211,515,000.00	211,515,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>888,026,536.99</b>	<b>928,559,079.33</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,460,000.00</b>	<b>2,460,000.00</b>



**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,460,000.00	2,460,000.00
413	<b>Өглөг</b>	2,460,000.00	2,460,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,460,000.00	2,460,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>885,566,536.99</b>	<b>926,099,079.33</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	370,681,841.07	370,681,841.07
	Дахин үнэлгээний нөөц	325,596,218.72	325,596,218.72
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>189,288,477.20</b>	<b>229,821,019.54</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	189,288,477.20	189,288,477.20
51220	Тайлант үеийн үр дүн		40,532,542.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>888,026,536.99</b>	<b>928,559,079.33</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>659,377,991.62</b>	<b>844,118,913.70</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,438,591.62</b>	<b>47,188,777.70</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,438,591.62	47,188,777.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,041,159.62	47,188,777.70
120009	Бусад орлого	397,432.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>640,939,400.00</b>	<b>796,930,136.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	629,089,400.00	794,053,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	629,089,400.00	794,053,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,850,000.00	2,876,536.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,850,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,876,536.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>658,200,866.93</b>	<b>803,586,371.36</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>658,200,866.93</b>	<b>803,586,371.36</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	635,171,851.17	774,214,698.63
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	484,969,564.18	586,687,543.90
210101	Үндсэн цалин	335,065,779.18	338,669,645.68
210102	Нэмэгдэл	134,939,385.00	207,973,946.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,964,400.00	40,043,952.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,052,497.00	73,395,838.74
210201	Тэтгэврийн даатгал	41,601,379.00	50,980,896.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,894,279.00	5,589,259.90



**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,881,824.00	4,486,848.55
210204	Ажилгүйдлийн даатгал	970,455.00	1,121,712.14
210205	Эрүүл мэндийн даатгал	9,704,560.00	11,217,121.61
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,644,779.55</b>	<b>7,578,055.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,986,514.02	3,677,088.74
210302	Түлш, халаалт	3,731,633.23	2,525,470.32
210303	Цэвэр, бохир ус	926,632.30	955,496.02
210304	Байрны түрээс	00.00	420,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,532,262.94</b>	<b>24,107,964.77</b>
210401	Бичиг хэрэг	6,679,386.00	8,226,008.00
210402	Тээвэр, шатахуун	4,369,601.00	5,193,880.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,057,885.94	3,275,631.37
210404	Ном, хэвлэл	138,000.00	255,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,801,440.00	1,143,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,520,460.00	3,951,995.00
210408	Бараа материал акталсны зардал	965,490.00	2,062,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>170,000.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	170,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,262,800.00</b>	<b>9,325,570.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,030,000.00
210604	Урсгал засвар	4,262,800.00	8,295,570.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,750,000.00</b>	<b>891,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,750,000.00	891,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,006,548.00</b>	<b>17,415,801.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,094,800.00	11,882,745.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,084,400.00	958,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,348.00	82,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	319,000.00
210807	Газрын төлбөр	622,000.00	3,409,736.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>49,783,399.50</b>	<b>54,812,125.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,300,000.00	4,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,141,000.00	10,931,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,342,399.50	39,080,225.14
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00



**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,029,015.76	29,371,672.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,102,300.00	470,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,162,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,940,000.00	470,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,926,715.76	28,901,672.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,926,715.76	28,901,672.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>1,177,124.69</b>	<b>40,532,542.34</b>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>1,177,124.69</b>	<b>40,532,542.34</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,681,841.07	325,596,218.72	189,288,477.20	885,566,536.99
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	370,681,841.07	325,596,218.72	189,288,477.20	885,566,536.99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,681,841.07	325,596,218.72	189,288,477.20	885,566,536.99
D08	Тайлант үеийн үр дүн			40,532,542.34	40,532,542.34
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,681,841.07	325,596,218.72	229,821,019.54	926,099,079.33

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<b>643,399,400.00</b>	<b>797,332,136.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,460,000.00	402,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,460,000.00	402,000.00
120009	Бусад орлого	2,460,000.00	402,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>640,939,400.00</b>	<b>796,930,136.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	629,089,400.00	794,053,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	629,089,400.00	794,053,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,850,000.00	2,876,536.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,850,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,876,536.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<b>634,693,720.00</b>	<b>766,457,136.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,693,720.00	766,457,136.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610,210,784.24	737,085,463.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	484,650,693.75	586,687,543.90





**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210101	Үндсэн цалин	315,363,116.35	338,669,645.68
210102	Нэмэгдэл	152,981,982.40	207,973,946.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,305,595.00	40,043,952.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,052,497.00</b>	<b>73,395,838.74</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,601,379.00	50,980,896.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,894,279.00	5,589,259.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,881,824.00	4,486,848.55
210204	Ажилгүйдлийн даатгал	970,455.00	1,121,712.14
210205	Эрүүл мэндийн даатгал	9,704,560.00	11,217,121.61
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,644,779.55</b>	<b>7,578,055.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,986,514.02	3,677,088.74
210302	Түлш, халаалт	3,731,633.23	2,525,470.32
210303	Цэвэр, бохир ус	926,632.30	955,496.02
210304	Байрны түрээс	00.00	420,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,745,065.94</b>	<b>24,335,954.55</b>
210401	Бичиг хэрэг	8,084,060.00	8,751,200.00
210402	Тээвэр, шатахуун	5,302,720.00	5,604,913.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,027,885.94	3,275,631.37
210404	Ном, хэвлэл	138,000.00	255,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,089,810.00	1,313,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,102,590.00	5,135,760.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,880,000.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,880,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,916,700.00</b>	<b>11,048,570.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00	1,953,000.00
210604	Урсгал засвар	4,666,700.00	9,095,570.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,750,000.00</b>	<b>891,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,750,000.00	891,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,130,048.00</b>	<b>17,415,801.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,218,300.00	11,882,745.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,084,400.00	958,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,348.00	82,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	319,000.00
210807	Газрын төлбөр	622,000.00	3,409,736.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,441,000.00</b>	<b>15,731,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,300,000.00	4,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,141,000.00	10,931,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,482,935.76</b>	<b>29,371,672.73</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,453,920.00	00.00



**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,453,920.00	00.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,102,300.00	470,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,162,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,940,000.00	470,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	5,926,715.76	28,901,672.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,926,715.76	28,901,672.73
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,705,680.00</b>	<b>30,875,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>7,699,600.00</b>	<b>30,875,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,699,600.00</b>	<b>30,875,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	7,699,600.00	30,875,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,699,600.00	30,875,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-7,699,600.00</b>	<b>-30,875,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	1,006,080.00	00.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,453,920.00	2,460,000.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	2,460,000.00	2,460,000.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	793,619,500.00	765,553,927.27
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	793,619,500.00	765,553,927.27
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	793,119,500.00	764,733,927.27
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	595,985,800.00	586,687,543.90
210101	Үндсэн цалин	357,443,400.00	338,669,645.68
210102	Нэмэгдэл	200,671,200.00	207,973,946.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,871,200.00	40,043,952.00
210104	Урамшуулал	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,073,200.00	73,395,838.74
210201	Тэтгэврийн даатгал	51,528,400.00	50,980,896.54
210202	Тэтгэмжийн даатгал	5,636,200.00	5,589,259.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,509,000.00	4,486,848.55
210204	Ажилгүйдлийн даатгал	1,127,200.00	1,121,712.14
210205	Эрүүл мэндийн даатгал	11,272,400.00	11,217,121.61
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,425,400.00	7,578,055.08
210301	Гэрэл, цахилгаан	5,172,000.00	3,677,088.74
210302	Түлш, халаалт	8,486,400.00	2,525,470.32
210303	Цэвэр, бохир ус	1,287,600.00	955,496.02



Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210304	Байрны түрээс	479,400.00	420,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,162,600.00</b>	<b>24,335,954.55</b>
210401	Бичиг хэрэг	10,187,500.00	8,751,200.00
210402	Тээвэр, шатахуун	6,200,000.00	5,604,913.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,500,000.00	3,275,631.37
210404	Ном, хэвлэл	375,100.00	255,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,313,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,900,000.00	5,135,760.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>43,348,000.00</b>	<b>41,923,570.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,500,000.00	16,832,700.00
210602	Тавилга	16,000,000.00	15,995,300.00
210604	Урсгал засвар	9,848,000.00	9,095,570.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,920,000.00</b>	<b>891,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,920,000.00	891,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,404,500.00</b>	<b>14,539,265.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,743,100.00	11,882,745.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	958,200.00	958,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,000.00	82,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	319,000.00	319,000.00
210807	Газрын төлбөр	533,200.00	533,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15800000.00</b>	<b>15731900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	4,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000,000.00	10,931,900.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>500000.00</b>	<b>470000.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>470,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	470,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>794,053,600.00</b>	<b>765,553,927.27</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>794,053,600.00</b>	<b>765,553,927.27</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	794,053,600.00	765,553,927.27
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>2,460,000.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>2,460,000.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00



**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,876,536.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,876,536.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,876,536.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,876,536.00
210807	Газрын төлбөр	2,876,536.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2876536.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,876,536.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,876,536.00
131106	Төсвийн урамшуулал	00.00

**3. Аудитын тайлан**

**3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын Гэрээт ажилтан Ж.Наранчимэг гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 246 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага бөгөөд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд



1. Байгууллагын үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэх
2. Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах
3. Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх
4. Чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих
5. Прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналт шалгалтын хэлтэсгүй.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 11,910.8 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт орлогын 794,053.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,910.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт орлогын 70 хувиар буюу 8,337.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,532.5 мянган төгрөгөөр буюу 2.42 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,460.0	2460.0	0
Бараа материал	18,134.3	23,173.1	5,038.8
Үндсэн хөрөнгө	867,030.2	902,925.8	35,895.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>888,026.5</b>	<b>928,559.0</b>	<b>40,532.5</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	885,566.5	926,099.0	40,532.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>885,566.5</b>	<b>926,099.0</b>	<b>40,532.5</b>

Бараа материалын данс 23,173.1 мянган төгрөг болж 5,038.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад ханамжийн материал худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 902,925.8 мянган төгрөг болж 35,895.6 мянган төгрөгөөр өссөн нь 44,913.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авч 128,787.7 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 926,099.0 мянган төгрөг болж 40,532.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Прокурорын газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 684,019.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 684,019.8 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 794,053.6 мянган төгрөгөөр төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 794,053.6 мянган төгрөгийг санхүүжилт улсын төсвөөс авч, урсгал үйл ажиллагаанд 765,152.0 мянган төгрөгийг зарцуулж 28,901.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 765,553.9 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 9,298.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 677.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7,847.4 мянган төгрөг, бусад хангамжийн материал 5,826.7 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 1424.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 865.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 2,876.5 мянган төгрөгийн орлого орж бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 2,876.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн Прокурорын газар нь 2021 онд нийт 797,681.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг хугацаа болоогүй, 2 мэдээллийн хугацааг хоцроон мэдээлсэн бөгөөд 147 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй зөвхөн нэхэмжлэхтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг



**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 29,210.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 402.0 мянган төгрөгийн албан шаардлага 1 хэрэгжилт 100 хувь хангагдсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1	29,210.0	1	29,210.0			
Албан шаардлага	1	402.0	1	402.1			
Нийт дүн	1	29,612.0	1	29,612.0			

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар цалин хөлсний тооцоолол үнэн зөв эсэх талаар авч үзнэ.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 5,883.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 425.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,890.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж, 568.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

**4.1 Залруулсан алдаа**

Тооцоолсон цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд 350.0 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлснийг, Бараа материалын шатахууны урамшуулал болох 75.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайлан дээр үнэ төлбөргүй авсан бараа материалын дансанд бүртгэж салгаж харагдуулахаар залруулж нийт 425.0 мянган төгрөгийг залруулав.

**4.3 Албан шаардлага**

**1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:**

Тайлант онд бага үнэтэй, түргэн элэгдэх зардлаас галын хор, хүрз, жоотуу, галын самбар зэргийг худалдан авч нийт 568.0 мянган төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж үр дүнтэй хяналттай байх зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:





**Орхон аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:**

Тайлант онд батлагдсан төсвөөс 4,890.8 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас дутуу бөглөсөн, шаардах хуудасны хүлээн авсан хүний гарын үсэг, олгосон хүний гарын үсэг, тэмдэг дутуу, Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын бүртгэл, зарцуулалтаар тавих хяналтыг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Прокурорын газар	3	5,883.8	1	425.0			1	568.0	1	4,890.8

/мянган төгрөгөөр/